



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.6, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 47 дугаар тогтоол, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-50, тус газрын дүрмийн 2.5.3, 3.1.17 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр, төрлийг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын жуулчдыг Улаанбаатар хот болон хот орчмоор ая тухтай аялах нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй “Сити тур” төслийн маркетинг сурталчилгааг эрчимжүүлэхийг Мэдээлэл сурталчилгааны хэлтэс /М.Болортуяа/-т даалгасугай.


2. Төслийн маркетинг, сурталчилгааны ажилд шаардагдах, энэ тушаалын хавсралтаар баталсан төсвийн 500 000 /таван зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Батцож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.БАТСҮХ



• 1150500275

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 07
сарын 09 өдрийн А/56 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



“СИТИ ТУР” ТӨСЛИЙН МАРКЕТИНГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ
ХОТЫН АЯЛЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСВИЙН
ЗАДАРГАА

№	Зарцуулалт	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Зураг авалт	1	200,000	200 000
2	Өсгөгчийн түрээс	2	150,000	300 000
Нийт				500 000

-ooOoo-